САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр | Дугаар 205 | Улаанбаатар хот

"Цагаан-Ажнай ББСБ" ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. "Цагаан-Ажнай ББСБ" ХХК-ийн банк бус санхүүгийн зээлийн, факторингийн, төлбөрийн баталгаа гаргах, гадаад валютын арилжааны, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тусгай зөвшөөрлийг сунгасан талаарх тэмдэглэлийг 2009 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хийлгэж хуулбарыг Хороонд ирүүлэхийг "Цагаан-Ажнай ББСБ" ХХК /Ш.Батцэнгэл/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА О.ГАНБАТ